

*Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын Удирдах Зөвлөлийн
2025 оны 1/23 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт*

**БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ҮНДСЭН
ЗАРДАЛ БОЛОН НЭМЭЛТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ**

**БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ҮНДСЭН
ЗАРДАЛ БОЛОН НЭМЭЛТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ**

Нэгдүгээр зүйл. Олон улсын маргааны арбитрын үндсэн зардлын хэмжээг нэхэмжлэлийн үнийн дүнгээс доорх хувь хэмжээгээр тогтооно. Үүнд:

/АНУ-ын доллараар/

	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын үндсэн зардал
1.	1-1'000	Үнийн дүнгийн 30 хувиар бодох
2.	1'001-5'000	300 дээр 1'000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар бодож нэмэх
3.	5'001-10'000	420 дээр 5'000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар бодож нэмэх
4.	10'001-50'000	570 дээр 10'000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар бодож нэмэх
5.	50'001-100'000	1'770 дээр 50'000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувийг нэмэх
6.	100'001-200'000	3'270 дээр 100'000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар бодож нэмэх
7.	200'001-500'000	6'270 дээр 200'000-аас дээш үнийн дүнгийн 2.5 хувиар бодож нэмэх
8.	500'001-1 '000'000	13'770 дээр 500'000-аас дээш үнийн дүнгийн 2.0 хувиар бодож нэмэх
9.	1 '000'001 -аас дээш	23'770 дээр 1'000'000-аас дээш үнийн дүнгийн 1.5 хувиар бодож нэмэх

Хоёрдугаар зүйл. Дотоодын маргаан шийдвэрлэх арбитрын үндсэн зардлын хэмжээг нэхэмжлэлийн үнийн дүнгээс доорх хувь хэмжээгээр тогтооно. Үүнд:

/Төгрөгөөр/

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын үндсэн зардал
1	1-1,000,000	Үүнийн дүнгийн 15 хувиар бодох
2	1,000,001-5,000,000	150'000 дээр 1'000'000-ээс дээш үнийн дүнгийн 3 хувиар бодож нэмэх
3	5,000,001-10,000,000	250'000 дээр 5'000'000-ээс дээш үнийн дүнгийн 3 хувийг нэмэх
4	10,000,001-50,000,000	375'000 дээр 10'000'000-аас дээш үнийн дүнгийн 2.5 хувиар бодож нэмэх
5	50,000,001-100,000,000	1'175'000 дээр 50'000'000-аас дээш үнийн дүнгийн 2 хувиар бодож нэмэх

6	100,000,001-200,000,000	2'025'000 дээр 100'000'000-аас дээш үнийн дүнгийн 1.75 хувиар бодож нэмэх
7	200,000,001-500,000,000	3'525'000 дээр 200'000'000-аас дээш үнийн дүнгийн 1.5 хувиар бодож нэмэх
8	500,000,001-1,000,000,000	7'425'000 дээр 500'000'000-аас дээш үнийн дүнгийн 1.3 хувиар бодож нэмэх
9	1,000,000,001-5,000,000,000	12'425'000 дээр 1'000'000'000-аас дээш үнийн дүнгийн 1 хувиар бодож нэмэх
10	5,000,000,001-10,000,000,000	44,425,000 дээр 5,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 0.8 хувиар бодож нэмэх
11	10,000,000,001-50,000,000,000	74,425,000 дээр 10,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 0.6 хувиар бодож нэмэх
12	50,000,000,001-100,000,000,000	234,425,000 дээр 50,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 0.4 хувиар бодож нэмэх
13	100,000,000,001-аас дээш	334,425,000 дээр 100,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 0.2 хувиар бодож нэмэх

Гуравдугаар зүйл. Арбитрын ажиллагааны үндсэн зардал

3.1. Арбитрын үндсэн зардалд Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах зардлыг ойлгоно. Үүнд:

3.1.1. Арбитрын үйлчилгээний хөлс

3.1.2. Арбитрын захиргааны зардал

3.1.3. Арбитрч, илтгэгч болон нарийн бичгийн даргын хөлс

3.2. Нэхэмжэгч нэхэмжлэл гаргахдаа арбитрын зардлыг урьдчилан төлнө.

3.3. Сөрөг нэхэмжлэл гаргасан тал нэхэмжлэгчийн нэгэн адил арбитрын зардал төлнө.

3.4. Нэхэмжлэгч тал арбитрын зардлыг хэсэгчлэн төлөх талаар арбитрт хүсэлт гаргаж болно. Хэсэгчлэн төлөх зардлын доод хэмжээ арбитрын нийт зардалын 50 хувиас доошгүй байна. Үлдэх хэсгийг арбитрын шийдвэр гарахаас долоогоос доошгүй хоногийн өмнө төлнө.

3.5. Нэхэмжлэгчээс шилжүүлсэн арбитрын зардал Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын удирдах зөвлөлийн дансанд орсноор уг зардлыг төлсөнд тооцно. Уг зардлыг дансанд оруулах үүргийг нэхэмжлэгч, түүний гүйцэтгэлийг шалгаж хэрэгжүүлэх үүргийг Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитр хариуцна.

3.6. Олон улсын маргааны арбитрын зардлын төлбөрийг АНУ-ын доллараар тооцож, "Төв банкны тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож Монгол төгрөгөөр төлнө.

3.7. Олон улсын маргааны арбитрын зардал нь АНУ-аас өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд арбитрын зардлыг нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцно.

3.8. дотоодын маргааны нэхэмжлэлийн үнийн дүн АНУ-ын доллараар эсвэл өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож арбитрын зардлыг төлнө.

3.9. Арбитрт анх нэхэмжлэл гаргахад нэхэмжлэл нь мөнгөн дүнгээр хэмжигдэх боломжгүй тохиолдолд 300'000 төгрөг төлнө.

3.10. Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэл нь мөнгөн дүнгээр хэмжигдэх боломжгүй тохиолдолд тухайн арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлно.

3.11. Аймгийн арбитрт шийдвэрлэх хэргийн хувьд арбитрын үндсэн зардлыг аймгийн арбитрын зардал тооцох журмын дагуу тухайн аймгийн арбитрын дансанд төлснөөр төлөгдсөнд тооцно.

3.12. Арбитрын үндсэн зардлыг энэ журмын 5 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд буцаан олгохгүй.

Дөрөвдүгээр зүйл. Арбитрын ажиллагааны нэмэлт зардал

4.1. Нэмэлт зардалд тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд холбогдох бусад зардал багтана. Үүнд: шинжээчтэй холбогдон гарах зардал, арбитрын шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт хамаарахгүй бол ажлын хөлс, үзлэг хийхэд гарсан зардал, шуудангийн зардал, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал, арбитрчдын болон нарийн бичгийн даргын томилолтын зардал, арбитрын байнгын байрлах газраас өөр газарт арбитрын хуралдаан хийсэнтэй холбогдсон зардал болон бусад зардал орно.

4.2. Арбитр аль нэг талаас эсвэл талуудаас хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт зардлыг урьдчилан төлүүлнэ. Нэмэлт зардалд төлсөн төлбөр илүү гарсан тохиолдолд арбитрын шийдвэр гарсны дараа тухайн илүү төлбөрийг буцаан олгоно.

4.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа хэрэгт байгаа нотлох баримт, албан бичгийн хуулбар, шийдвэр зэргийг хуулбарлан авахад хуудас тутамд 3'000 төгрөг төлнө.

Тавдугаар зүйл. Арбитрын ажиллагааны зардлаас буцаан олгох

5.1. Арбитрын ажиллагааны журмыг батлахаас өмнө нэхэмжлэгч нэхэмжлэлээ буцаан авсан, талууд эвлэрэн хэлэлцсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснээр арбитрын ажиллагааг дуусгавар болгосон бол арбитрын үндсэн зардлын төлбөрийн 60 хувийг нэхэмжлэгчид буцаан олгоно.

5.2. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан хийхээс өмнө талууд эвлэрэн хэлэлцсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээ буцаан авсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснээр арбитрын ажиллагааг дуусгавар болгосон бол тухайн арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааны бодит зардлыг тооцон арбитрын үндсэн зардлын төлбөрийн 50 хүртэл хувийг нэхэмжлэгчид буцаан олгож болно.

5.3. Арбитрын ажиллагааны явцад арбитрын хэлэлцээр хүчингүй болох, тус арбитрын харьяалалын маргаан биш болох нь тогтоогдсон тохиолдолд арбитрын зардлын 50 хувийг нэхэмжлэгчид буцаан олгоно.

5.4. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан хийхээс өмнө талууд эвлэрэн хэлэлцэж хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын орлогод үлдсэн зардлыг талуудад тэнцүү хувиар хариуцуулж болно.

Зургаадугаар зүйл. Арбитрын ажиллагаатай холбоотой бусад зардал

6.1. Аль нэг талын сонгосон арбитрч арбитрын ажиллагаа явуулах газарт байнга оршин суудаггүй тохиолдолд түүний арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зардлыг сонгосон тал төлнө. Хэрэв ийм арбитрч арбитрын бүрэлдэхүүний даргалагчаар томилогдсон бол түүнийг арбитрын ажиллагаанд оролцоход гарах зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.

Долоодугаар зүйл. Арбитрын ажиллагааны зардлын талаарх талуудын эрх

7.1. Аль нэг тал арбитрын ажиллагаатай холбогдон өөрөөс гарсан нэмэлт зардлыг буруутай талаас нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр энэхүү журамд заасны дагуу арбитрын зардлыг төлнө.

7.2. Аль нэг талын хүсэлтээр арбитрын хуралдаанд орчуулга хийх, баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг хүсэлт гаргасан тал төлнө. Арбитрын бүрэлдэхүүний санаачлагаар баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө. Хэрэв талууд харилцан тохиролцон хуралдааныг Монгол хэлээс өөр хэлээр явуулахаар бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.

7.3. Аль нэг талын хүсэлтээр шинжээч томилох бол шинжээчийн зардлыг хүсэлт гаргасан тал, Арбитрын бүрэлдэхүүний санаачлагаар шинжээч томилох бол шинжээчийн зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.